

МОНГОЛ-ОРОСЫН 1912 ОНЫ ГЭРЭЭНИЙ 95 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН “МОНГОЛ-ОРОСЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХИЙН ШИНЭ ХАНДЛАГА БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ” СЭДЭВТ ДУГУЙ ШИРЭЭНИЙ ЯРИЛЦЛАГА

Монгол-Оросын 1912 оны гэрээний 95 жилийн ойд зориулсан “Монгол-Оросын харилцааны түүхийн шинэ хандлага ба өнөөгийн байдал” сэдэвт дугуй ширээний ярилцлага Улаанбаатар хотноо 2007 оны 10 дугаар сарын 23-нд болж өнгөрөв.

Энэхүү дугуй ширээний ярилцлагыг Монголд болж буй ОХУ-ын Сибирийн шинжлэх ухааны өдрүүдийн хүрээнд ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн, ОХУ-ын Элчин Сайдын Яам, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбар дахь Буриадын эрдэм шинжилгээний Төв зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулав. Тус уулзалтыг ШУА-ийн ОУСХ-ийн захирал, доктор, профессор Л.Хайсандай, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Буриадын эрдэм шинжилгээний төв, Монгол, будда, түвд судлалын хүрээлэнгийн захирал Базаров Борис Ванданович нар даргалж ШУА-ийн Тэргүүлэгчдийн байрны хурлын танхимд болж өнгөрөв. Уг дугуй ширээний ярилцлагад ОХУ-ын Элчин сайдын яамны зөвлөх Мостыко Иван Сергеевич, Ганжуров Владимир Цеденович, МУ-ын ГХЯ-ны Хөрш орнуудын газрын ажилтан Л.Баттулга, Олон Улсын харилцааны дээд сургуулийн захирал Н.Алтанцэцэг, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор Н.Хишигт, Буриадын эрдэм шинжилгээний төвийн захирал Базаров Борис Ванданович зэрэг 50 орчим эрдэмтэн судлаач, албаны хүмүүс оролцов. Тус хуралд тавигдсан илтгэлүүд:

1. *“Российско-Монгольский договор 1912 года и его значение”* - О.Батсайхан, ШУА-ийн ОУСХ-ийн Орос судлалын секторын эрхлэгч, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор.
2. *“Россия и Монголия в геополитическом пространстве Центральной Азии”* - Б.В.Базаров, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Буриадын эрдэм шинжилгээний төв, Монгол, будда, түвд судлалын хүрээлэнгийн захирал.
3. *“Взаимоотношение России и Монголии на современном этапе”* - Л.Баттулга, ГХЯ-ны Хөрш орнуудын газрын ажилтан.
4. *“Россия и Монголия: современность и перспективы”* - И.С.Мостыко, ОХУ-ын ЭСЯ-ны зөвлөх.
5. *“Взаимоотношения России и Монголии в военной области в 1911-1919 гг.”* - Н.Хишигт, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор.

6. *“Личные архивы и изучение истории современной Монголии на примере личных архивов Моррисона, Ларсона и Котвича”* - Ө.Тайван, Өвөр Монголын Их сургуулийн доктор.
7. *“Бурятия и Монголия: региональное сотрудничество на современном этапе”* - С.Д.Тубчинов, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, будда, түвд судлалын хүрээлэнгийн ажилтан.

Эрдэмтэн судлаачид уг илтгэлүүдийн талаар санал сэтгэгдэлээ солилцож, өөр өөрийн санал бодлоо хуваалцан, сонирхсон асуултуудыг тавин дэлгэрэнгүй хариулт авч, маш үр дүн бүхий ярилцлага болсоныг онцлон тэмдэглэлээ. Дугуй ширээний ярилцлагын гол үр дүнд Монгол-Оросын харилцааны нэн шинэ түүхийн 90-ээд оноос хойшхи судалгааг улам гүнзгийрүүлж, орчин үеийн байдалд тулгуурлан өргөжүүлэн судлах шаардлага бий болсоныг онцлон, цаашид энэхүү дугуй ширээний ярилцлагыг тогтмолжуулах нь зүйтэй гэдэг дээр эрдэмтэн судлаачид санал нэгдэв. Дугуй ширээний ярилцлагын төгсөлд “Российский фактор в установлении независимости Монголии в XX веке” хамтарсан төслөөс уг дугуй ширээний ярилцлагын материалыг орос хэл дээр хэвлүүлэхээр болов.

*Мэдээ бэлтгэсэн Ж.Орхон (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан)*